



ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

ХАРААТ БУС АУДИТОРЫН НЯГТЛАХ ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЙЛАН "БӨӨНИЙ ХУДАЛДАА" ХК-ИЙН ЗАХИРАЛ Б.ОЧБАДРАХ ТАНАА

Бид "Бөөний худалдаа" ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх баланс ба уг өдрөөр дуусвар болсон жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний холбогдох тайланг шалгалаа. Эдгээр санхүүгийн тайлангийн агуулгыг компанийн удирдлага хариуцна. Бидний үүрэг хариуцлага бол өөрсдийн гүйцэтгэсэн шалгалтанд үндэслэн эдгээр санхүүгийн тайлангийн талаар тайлан гаргах явдал юм.

Бид энэхүү гэрээт нягтлах ажлыг Нягтлах гэрээт ажлын олон улсын стандарт 2400-н дагуу гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар дунд түвшний баталгаа олж авахын тулд шалгалтыг төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Нягтлах гэрээт ажил үндсэндээ компанийн боловсон хүчнээс асуулга авах болон санхүүгийн тоон мэдээнд шинжилгээ хийх горимоор хязгаарлагдсан.

Нягтлах гэрээт ажлаа үндэслэн дүгнэхэд, энд хавсаргасан санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Монгол улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдээгүй гэж үзэхэд хүргэх ямар нэгэн зүйл бидний анхааралд өртөөгүй болно.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ:

АУДИТОР

Ч.ОЮУН

